МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 22 өдөр Дугаар А/17 Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Аймаг, нийслэлийн дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийг бүтэц зохион байгуулалтын дагуу тухайн хэлтсийн батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаарт багтаан зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ю.Идэрцогт/-д, Хөдөлмөрийн хэлтсийн төсөв, орон тоонд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газар /Б.Пүрэвсүрэн/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/127 дугаар тушаалын холбогдох хэсгийг, мөн 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/253 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Г.БАЯРСАЙХАН

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ
ТЕАГУТҮГ
ХУУЛБАР ҮНЭН
Гарын үсэг:
2016 он 01 сар 22 өдөр

0000000072

Хөдөлмөрийн сайдын 2016 оны
01...дугаар сарын 22-ны өдрийн
А/17...тоот тушаалын 5. дугаар хавсралт

# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН БҮТЭЦ, ОРОН ТООНЫ БҮДҮҮВЧ

/нийт 24 орон тоо/

**Хэлтсийн дарга**

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, бодлогын хэрэгжилт, мэргэжлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн-1
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтнүүд-2
- Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн-1
- Хөдөлмөрийн судалгаа, дүн шинжилгээ, тэдгээрийн тайлан, хүний нөөц, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн-1
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, програм хангамж, мэдээллийн сан, ажил олгогч, ажлын шинэ байрны мэдээлэл, тайлан хариуцсан мэргэжилтэн-1
- Ажилд зуучлал, ажил хайгч, ажилгүй иргэдийн болон ажлын байрны захиалгын бүртгэл, тайлан хариуцсан мэргэжилтэн-0,5
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн-0,5
- Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ, үйл ажиллагааны тайлан хариуцсан мэргэжилтэн-1
- Сум /баг/, хороонд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн-8
- Нягтлан бодогч /ХЭДСан, Үйл ажиллагаа/-1
- Даргын туслах, архив, бичиг хэрэг, нярав-1
- Жолооч-1
- Үйлчлэгч, манаач, галч зэрэг үйлчилгээний ажилтнууд-4